



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 3 өдөр

Дугаар 4150

Улаанбаатар хот

Нийслэлийн өмчийн бүртгэлээс
барилга байгууламж хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 78 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 49 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр барилга баригдах болсонтой холбогдуулан Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтсийн балансад бүртгэлтэй, 77,436,915.70 (далан долоон сая дөрвөн зуун гучин зургаан мянга есөн зуун арван таван төгрөг далан мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий, хавсралтад заасан барилгыг акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хасахыг Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтэс (Б.Батбилэг)-т зөвшөөрсүгэй.

2.Акталж, данснаас хасагдаж байгаа барилгын хоёрдогч түүхий эдийн зориулалтаар дахин ашиглах боломжтой материалыг худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (Ч.Сайханбаяр)-т даалгасугай.

3.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (И.Баатархүү)-т үүрэг болгосугай.


НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

Д.СУМЪЯАБАЗАР



111020317

Нийслэлийн Засаг даргын 2023 оны
...сарын...-ны өдрийн
...захиралжийн
...жагсаалт



АКТАЛЖ, НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ

№	Барилга байгууламжийн нэр	Ашиглалтад орсон он	Бүртгэлийн үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг /2022.12.31/	Акталж, данснаас хасах үндэслэл
1	Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтсийн агуулах, авто тавиулангийн барилга	2012	77,436,915.70	9,110,225.28	68,326,690.42	Нийслэлийн хот байгуулалт, хөгжлийн газрын 2022 оны "Паспортжуулалтын мэргэжлийн дүгнэлт"-ээр болзошгүй газар хөдлөлтөд тэсвэргүй гэж дүгнэгдсэн.
НИЙТ			77,436,915.70	9,110,225.28	68,326,690.42	